### 3.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

#### 3.2.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. ДИЗАЙН, ЗУРАГ ЗҮЙ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДТ8.1.ҮД1.Сурагч деталийг ортогональ ба аксонометрийн проекцын аргаар, параболын муруйг F фокус цэгийн аргаар зурдаг.	ДТ8.1.ҮД1. Ш1. Зураг зүйн дүрэм стандартаар деталийн нэгдсэн ортогональ проекцыг зурдаг.
		ДТ8.1. ҮД1.Ш2. Зураг зүйн дүрэм стандартаар деталийн аксонометр проекцын аргаар зурдаг.
		ДТ8.1.ҮД1.Ш3. Параболын муруйг F фокус цэгийн аргаар зурж тайлбарладаг.
2	ДТ8.1.ҮД2. Сурагч ортогональ, аксонометрийн проекцын аргаар эд зүйлсийн загварыг төлөвлөн зурж, бүтээдэг.	ДТ8.1.ҮД2. Ш4. Ортогональ болон аксонометрийн проекцын аргаар эд зүйлсийн (сав, баглаа, боодол) загварыг төлөвлөн зурдаг.
		ДТ8.1.ҮД2.Ш5. Загварын төлөвлөлтийн дагуу эд зүйлсийн (сав, баглаа, боодол) биет загварыг бүтээдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
ДТ8.1.ҮД1.Ш1. Зураг зүйн дүрэм стандартаар деталийн нэгдсэн ортогональ проекцыг зурдаг.	Зураг зүйн дүрэм стандартын дагуу харилцан перпендикуляр ортогональ проекцын тэнхлэг байгуулдаг.	Зураг зүйн дүрэм стандартын дагуу деталийн нүүрний проекцыг нэгдсэн дээр тооцоолон зурдаг.	Зураг зүйн дүрэм стандартын дагуу деталийн хэвтээ ба хажуугийн проекцыг параллел проекцын аргаар зурдаг.	Зураг зүйн дүрэм стандартаар геометр биет ба деталийг нэгдсэн ортогональ проекцын аргаар зурдаг.
ДТ8.1.ҮД1.Ш2. Зураг зүйн дүрэм стандартаар деталийн аксонометр проекцыг зурдаг.	Зураг зүйн дүрэм стандартын дагуу деталийн аксонометр (диметр, изометр) проекцын тэнхлэгийг (X,Y,Z) байгуулдаг.	Зураг зүйн дүрэм стандартын дагуу деталийг диметрийн проекцын тэнхлэг дээр зурдаг.	Зураг зүйн дүрэм стандартын дагуу деталийг изометр проекцын тэнхлэг дээр зурдаг.	Зураг зүйн дүрэм стандартын дагуу деталийг (диметр, изометр) аксонометр проекцыг зурдаг.
ДТ8.1.ҮД1.Ш3. Параболын муруйг F фокус цэгийн аргаар зурж тайлбарладаг.	Параболын муруйг амьдралын бодит жишээтэй холбож тайлбарладаг.	Параболын муруйн тэнхлэг байгуулан F фокус цэгийг олж, хэрчмээ дурын хэмжээтэй хувааж, оройн 0 цэгийг тэмдэглэдэг.	Оройн 0 цэгээс дугаарласан цэгүүд дээр босоо чиглэлд параллел шулуунуудыг татаж, F цэгээс босоо шугамд нумаар огтолж хязгаарын цэгүүдийг олдог.	Оройн 0 цэгээс хоёр тийш тэмдэглэсэн цэгүүдийг холбож параболын муруйг байгуулж тайлбарладаг.
ДТ8.1.ҮД2. Ш4. Ортогональ болон аксонометрийн проекцын аргаар эд зүйлсийн (сав, баглаа, боодол) загварыг төлөвлөн зурдаг.	Эд зүйлсийн (сав, баглаа, боодол) загварын санаагаа тойм зургаар зурдаг.	Эд зүйлсийн (сав баглаа боодол) загварыг ортогональ проекцын аргаар зурдаг.	Эд зүйлсийн (сав баглаа боодол) загварыг аксонометр проекцын аргаар зурдаг.	Ортогональ болон аксонометрийн проекцын аргаар эд зүйлсийн (сав, баглаа, боодол) загварыг төлөвлөн зурдаг.
ДТ8.1.ҮД2.Ш5. Загварын төлөвлөлтийн дагуу эд зүйлсийн (сав, баглаа, боодол) биет загварыг бүтээдэг.	Загварын төлөвлөлтийн дагуу эд зүйлсийн (сав, баглаа, боодол) дэлгээсийг зурж байгуулдаг.	Эд зүйлсийн (сав, баглаа, боодол) дэлгээсийг төлөвлөлтийн дагуу загварчилдаг.	Загварын төлөвлөлтийн дагуу эд зүйлсийн (сав, баглаа, боодол) биет загварыг бүтээдэг.	Эд зүйлсийн (сав, баглаа, боодол) биет загварыг хэрэглээнд нийцүүлэн чимэглэдэг. (компьютер)

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

### 3.2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ /А ГРУПП/

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДТ8.2.ҮД3. Сурагч оёдлын цахилгаан машинаар энгийн оёдлын төрлүүдийг ААД баримтлан оёж чаддаг болно.	ДТ8.2.ҮД3.Ш1. Оёдлын машиныг бүтэц, эд ангийг судлах замаар ажилд бэлтгэж чаддаг.
		ДТ8.2.ҮД3.Ш2. Оёдлын цахилгаан машинаар энгийн оёдлын төрлүүдийг оёдог.
2	ДТ8.2.ҮД4. Сурагч юбкыг (шулуун, наран) технологийн дагуу эсгэж, оёж чаддаг болно.	ДТ8.2.ҮД4.Ш3. Биеийн хэмжээг тооцоолох аргаар (эсгүүр байгуулах аргачлал) юбканы (шулуун, наран) эсгүүр байгуулдаг.
		ДТ8.2.ҮД4.Ш4. Юбканы эсгүүрийг загварчлах арга (танаасыг хаах, шилжүүлэх, параллел ба конус шилжүүлэлт хийх)-аар эсгүүрт өөрчлөлт хийдэг.
		ДТ8.2.ҮД4.Ш5. Материалын шинж чанарыг тодорхойлох замаар юбканы материалыг сонгож, технологи дарааллын дагуу эсгэдэг.
		ДТ8.2.ҮД4.Ш6. Технологи дарааллын дагуу юбка оёдог.
3	ДТ 8.2.ҮД5. Сурагч хос зүүний сүлжих технологиор жижиг эдлэл сүлжиж чаддаг болно.	ДТ8.2.ҮД5.Ш7. Хос зүүний сүлжмэлийн гогцооны төрлүүдийн схем тэмдэглэгээгээр сүлжмэлийн төрлүүдийг (энгийн, хоёр талт, хээ үүсгэх гэх мэт) сүлждэг.
		ДТ8.2.ҮД5.Ш8. Схем зургийн дагуу хэрэгцээт жижиг эдлэл сүлждэг.
4	ДТ 8.2.ҮД6. Сурагч ширээ засалт (тодорхой зориулалтын)-д зориулсан зууш, ундаа, амттан бэлтгэж хооллох соёлыг тайлбарлаж чаддаг болно.	ДТ8.2.ҮД6.Ш9. Ширээ засалт (тодорхой зориулалтын)-д зориулсан зууш, амттан, ундааг технологийн дагуу хийдэг.
		ДТ8.2.ҮД6.Ш10. Хооллох соёлыг тодорхой зориулалтын ширээ засалтын жишээгээр тайлбарладаг.

#### Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
ДТ8.2.ҮД3.Ш1. Оёдлын машиныг бүтэц, эд ангийг судлах замаар ажилд бэлтгэж чаддаг.	Оёдлын цахилгаан машины эд ангиудыг таньж нэрлэдэг.	Оёдлын цахилгаан багаж хэрэгслийн (оёдлын машин) эд ангиудын үүрэг зориулалт, ажиллах зарчмыг тайлбарладаг.	Оёдлын цахилгаан багаж хэрэгслээр (оёдлын машин)-аар оёх үед гарч болох жижиг гэмтлүүдийг илрүүлж тохируулдаг.	Зааврын (дээд доод утсыг дарааллын дагуу сүвлэж) дагуу оёдлын машиныг ажилд бэлтгэдэг.
ДТ8.2.ҮД3.Ш2. Оёдлын цахилгаан машинаар энгийн оёдлын төрлүүдийг оёдог.	Машины энгийн оёдлын төрлүүдийг харьцуулж ялгааг тайлбарладаг.	Нийлүүлэх оёдол (хавсрах, хавсраад дарж оёх, дан дарж оёх, өнгө дотроос нь оёх)-ыг технологийн дагуу оёдог.	Зах ирмэг бэлтгэх оёдол (ирмэг битүү нугалж оёх, ирмэг задгай нугалж оёх, эмжиж оёх)-ыг технологийн дагуу оёдог.	Оёдлын машинаар энгийн оёдлын төрлүүдийг ААД баримтлан оёдог.
ДТ8.2.ҮД4.Ш3. Биеийн хэмжээг тооцоолох аргаар (эсгүүр байгуулах аргачлал) юбканы (шулуун, наран) эсгүүр байгуулдаг.	Биеэс хэмжээ авах аргачлалын дагуу хэмжээнүүд (Тб, Тө, Ун, Уэ)-ийг авдаг.	Биеэс хэмжээ авч тооцоолох аргаар шулуун юбканы суурь эсгүүрийн тор байгуулдаг.	Биеэс хэмжээ авч тооцоолох аргаар шулуун юбканы бүрдэл хэсгүүдийн (ар тал, урд тал, бүс) суурь эсгүүрийг байгуулдаг.	Биеийн хэмжээгээр тооцоолох аргаар шулуун болон наран юбканы эсгүүр (М1:1, М1:4 хэмжээ) байгуулдаг.

**ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР**

ДТ8.2.ҮД4.Ш4. Юбканы эсгүүрийг загварчлах арга (танаасыг хаах, шилжүүлэх, параллел ба конус шилжүүлэлт хийх)-аар эсгүүрт өөрчлөлт хийдэг.	Юбканы зохион бүтээлтийн шугамуудыг эсгүүрийн зурагт тодорхойлдог.	Юбканы загварын онцлогт тохирсон загварчилгааны аргыг сонгодог.	Өөрийн хүссэн юбканы загварт нийцүүлэн загварчлалын аргуудаас сонгож суурь эсгүүрт өөрчлөлт хийдэг.	Өөрийн хүссэн загварт нийцүүлэн суурь эсгүүрт өөрчлөлт хийх замаар шинэ загвар зохион бүтээдэг.
ДТ8.2.ҮД4.Ш5. Материалын шинж чанарыг тодорхойлох замаар юбканы материалыг сонгож, технологи дарааллын дагуу эсгэдэг.	Материал (даавуу)-ын суналт, үрчийлт, сэмрэлт, хэлбэрээ алдах, тоос татах шинж чанарыг тодорхойлж тайлбарладаг.	Материал (даавуу)-ын орцыг тооцож, юбканы загварын онцлог, хэрэглээнд нийцүүлэн сонгодог.	Юбканы урт, бүрдэл хэсгийг харьцуулан тодорхойлох замаар даавууны орцыг тооцож материалыг эсгүүрт бэлтгэдэг.	Материал (даавуу) дээр юбканы үлгэрийг материалын үндсэн утасны чиглэлийн дагуу байрлуулан эсгүүрийн шугамыг зурж тэмдэглэн юбканы бүрдэл хэсгүүдийг эсгэдэг.
ДТ8.2.ҮД4.Ш6. Технологи дарааллын дагуу юбка оёдог.	Юбка оёх технологи ажилбарын дарааллыг төлөвлөдөг.	Юбка оёх технологи төлөвлөлтийн дагуу бүрдэл хэсгүүдийг (бүс, танаас, хуниас, хормой, товчлогдох хэсэг) ААД баримтлан оёдолд бэлтгэдэг.	Юбканы бүрдэл хэсгүүдийг технологи дарааллын дагуу нэгтгэн ААД баримтлан оёдог.	Өөрийн хүссэн загварын юбкыг технологи дарааллын дагуу оёдог.
ДТ8.2.ҮД5.Ш7. Хос зүүний сүлжмэлийн гогцооны төрлүүдийн схем тэмдэглэгээгээр сүлжмэлийн төрлүүдийг (энгийн, хоёр талт, хээ үүсгэх гэх мэт) сүлждэг.	Хос зүүний сүлжмэлийн гогцооны төрлүүдийн схем тэмдэглэгээг таньж нэрлэдэг.	Хос зүүний сүлжмэлийн гогцооны төрлүүдээр (ар, өнгөн, тохоост) сүлждэг.	Хос зүүний сүлжмэлийн схем зургийг уншиж сүлждэг.	Хээ үүсгэн схем зураг зохиож сүлждэг.
ДТ8.2.ҮД5.Ш8. Схем зургийн дагуу хэрэгцээт жижиг эдлэл сүлждэг.	Хэрэгцээнд нийцсэн жижиг эдлэлийн загварын санааг зургаар илэрхийлдэг.	Шаардлагатай сүлжмэлийн багаж хэрэгсэл, утсыг тохируулан сонгодог.	Хос зүүгээр сүлжих эдлэлийн бүрдэл хэсгийг тооцоолж схем зургийг зурдаг.	Схем зургийн дагуу жижиг эдлэлийг ААД баримтлан хос зүүгээр сүлждэг.
ДТ8.2.ҮД6.Ш9. Ширээ засалт (тодорхой зориулалтын)-д зориулсан зууш, амттан, ундааг технологийн дагуу хийдэг.	Тодорхой зориулалтын (төрсөн өдрийн гэх мэт) ширээ засалтад шаардлагатай зууш, ундаа, амттаны цэсийг зохиодог.	Цэсийн дагуу зууш, ундаа, амттаны орц, найрлагыг тооцоолдог.	Орц найрлагад тохируулан эрүүл хүнсний бүтээгдэхүүнийг сонгодог.	Тодорхой зориулалтын ширээ засалтанд зориулсан зууш, ундаа амттаныг технологи дарааллын дагуу ААД баримтлан хийдэг.
ДТ8.2.ҮД6.Ш10. Хооллох соёлыг тодорхой зориулалтын ширээ засалтын жишээгээр тайлбарладаг.	Ширээ засалтын төрлүүдийн ялгааг жишээн дээр тайлбарладаг.	Хооллох ширээний ард зөв суух, соёлтой үйлчлүүлэх жишээн дээр хооллох, соёлыг тайлбарладаг.	Хооллох соёлыг ширээний хэрэгслийг (амны алчуур, таваг, халбага, сэрээ, аяга гэх мэт) бэлтгэн, хэрэглэх жишээн дээр тайлбарладаг.	Хооллох соёлыг тодорхой зориулалтын ширээ засалтын жишээн дээр тайлбарладаг.



## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

### 3.2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ /Б ГРУПП/

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДТ8.2.ҮД7. Сурагч мод боловсруулах гар болон энгийн цахилгаан багаж (цахилгаан суурин өрөм, уран хөрөө, гар хөрөө, харуул, зүлгүүр), технологи (тайрах, тууш зүсэх, харуулдах, зүлгэх, өнгөлөх) -оор модон тоглоом хийж чаддаг болно.	ДТ8.2.ҮД7.Ш1. Модон материалын механик шинж чанар (бат бөх, хатуу, гулзайлт)-ыг тодорхойлж эдлэлийн материалыг сонгодог.
		ДТ8.2.ҮД7.Ш2. Мод боловсруулах гар ба цахилгаан багаж (цахилгаан суурин өрөм, уран хөрөө, харуул)-аар (тайрах, тууш зүсэх, харуулдах, зүлгэх, нүхлэх, өнгөлөх) технологийг гүйцэтгэж чаддаг болно.
		ДТ8.2.ҮД7.Ш3. Модон материалыг боловсруулах технологи (тайрах, тууш зүсэх, харуулдах, зүлгэх, өнгөлөх)-оор ААД баримтлан модон тоглоом хийж бүтээдэг.
2	ДТ8.2.ҮД8. Сурагч металл боловсруулах гар багаж (төмрийн хайч, алх дөш, бахь, зүлгүүр), технологи (тайрах, тууш зүсэх, хасуурдах, зүлгэх, өнгөлөх) -оор жижиг эдлэл хийж чаддаг болно.	ДТ8.2.ҮД8.Ш4. Металлын технологийн шинж чанарыг нугалах, хугалах, хайчлах, хуурайдах, хөрөөдөх, хасуурдах аргаар тодорхойлж хийх эдлэлд нийцүүлэн сонгодог.
		ДТ8.2.ҮД8.Ш5. Металл боловсруулах гар багаж (төмрийн хайч, алх дөш, бахь, зүлгүүр, хасуур)-аар, (тайрах, тууш зүсэх, хасуурдах, зүлгэх, өнгөлөх) технологийг гүйцэтгэж чаддаг болно.
		ДТ8.2.ҮД8.Ш6. Металл боловсруулах технологи (тайрах, тууш зүсэх, хасуурдах, зүлгэх, өнгөлөх)-оор ААД баримтлан жижиг эдлэл зохион бүтээдэг.
3	ДТ8.2.ҮД9. Сурагч хуванцрын төрөл ангиллыг гадаад шинж чанараар нь тодорхойлж эдлэл зохион бүтээх ажилдаа сонгож чаддаг болно.	ДТ8.2.ҮД9.Ш7. Хуванцрын төрөл (реактопластын ба термопластын хуванцар) ангиллыг гадаад шинж чанараар нь тодорхойлж сонгодог.

### 3.2.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. ТЕХНИК

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДТ8.3.ҮД10. Сурагч техникийн (нисэх онгоцны) хөгжлийн түүх, нисэх загварын төрөл ангилал, механизмын бүтэц, эд анги ажиллах зарчмыг судалж жишээгээр тайлбарлаж чаддаг болно.	ДТ8.3.ҮД10.Ш1. Техникийн (нисэх онгоц) түүхэн хөгжил, нисэх загварын төрөл ангиллыг тодорхойлж тайлбарладаг.
		ДТ8.3.ҮД10.Ш2. Дамжуулгын механизм (мальтын, тээглүүрт, хавтгайн, тахир гол штануны бүтэц)-ын ажиллах зарчим, зориулалтыг тайлбарладаг.
2	ДТ8.3.ҮД11. Сурагч механик дамжуулга, энгийн хэлхээнээс бүрдсэн электроникийн бүрдэл хэсэгтэй хялбар хийцтэй хөдөлгөөнт бүтээл хийж чаддаг болно.	ДТ8.3.ҮД11.Ш3. Электроникийн бүрдэл хэсгүүдийн төрөл ангилал, тэдгээрийн бүтэц, үүрэг зориулалт, ажиллах зарчмыг тодорхойлж тайлбарладаг.
		ДТ8.3.ҮД11.Ш4. Механизм болон энгийн цахилгаан хэлхээ бүхий хялбар хийцтэй техникийн бүтээлийг технологийн дагуу ААД баримтлан хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
ДТ8.3.ҮД10.Ш1. Техникийн (нисэх онгоц) түүхэн хөгжил, нисэх загварын төрөл ангиллыг тодорхойлж тайлбарладаг.	Техникийн хөгжлийн үе шатыг нисэх онгоцны жишээн дээр тайлбарладаг.	Техникийн хөгжил (загвар, технологи)-ийн өөрчлөлтийг нисэх онгоцны жишээгээр харьцуулж тайлбарладаг.	Техникийн хөгжлийг нисэх загварын спорт, түүний төрлүүдтэй холбож тайлбарладаг.	Техникийн (нисэх онгоц) түүхэн хөгжил, нисэх загварын төрөл ангиллыг тодорхойлж тайлбарладаг.
ДТ8.3.ҮД10.Ш2. Дамжуулгын механизм (мальтын, тээглүүрт, хавтгайн, тахир гол штануны бүтэц)-ын ажиллах зарчим, зориулалтыг тайлбарладаг.	Дамжуулгын механизм (мальтын, тээглүүрт, хавтгайн, тахир гол шатун)-ын бүтэц эд ангийг нэрлэдэг.	Дамжуулгын механизм (мальтын, тээглүүрт, хавтгайн, тахир гол шатун)-ын үүрэг зориулалтыг тайлбарладаг.	Дамжуулгын механизм (мальтын, тээглүүрт, хавтгайн, тахир гол шатун)-ын ажиллах зарчим зориулалтыг тайлбарладаг.	Дамжуулгын механизм (мальтын, тээглүүрт, хавтгайн, тахир гол шатун) төрлүүдийг харьцуулан тайлбарладаг.
ДТ8.3.ҮД11.Ш3. Электроникийн бүрдэл хэсгүүдийн төрөл ангилал, тэдгээрийн бүтэц, үүрэг зориулалт, ажиллах зарчмыг тодорхойлж тайлбарладаг.	Электроникийн энгийн элементүүдийн график тэмдэглэгээг таньж нэрлэдэг.	Электроникийн бүрдэл хэсгийн төрөл ангилал, тэдгээрийн бүтцийг тодорхойж тайлбарладаг.	Электроникийн бүрдэл хэсгийн үүрэг зориулалт, ажиллах зарчмыг тодорхойлж тайлбарладаг.	Электроникийн энгийн элементүүдийн график тэмдэглэгээ бүхий хэлхээг жишээгээр тайлбарладаг.
ДТ8.3.ҮД11.Ш4. Механизм болон энгийн цахилгаан хэлхээ бүхий хялбар хийцтэй техникийн бүтээлийг технологийн дагуу ААД баримтлан хийдэг.	Техникийн бүтээлийн загварын санаа, хөдөлгөөн хувиргах үйл явц, ажиллах зарчмыг зурж тайлбарладаг.	Техникийн бүтээлийн эд ангийн тойм зураг болон механик ба электроникийн бүдүүвч (схем) зургийг зурдаг.	Технологийн дагуу ААД баримтлан техникийн бүтээлийн эд анги (механик ба электроник)-ийг бэлтгэх, холбож угсардаг.	Техникийн бүтээлийн хөдөлгөөн дамжуулах механизм, электроникийн эд ангийн ажиллагааг туршиж сайжруулдаг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IX АНГИ

4.1. IX АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилтын код, өгүүлбэр	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	9.1г. Деталийг хавтгайгаар огтолж шилжүүлсэн, давхцуулсан дүрслэлийн аргаар деталийн ортогональ проекцод огтлол хийсэн байдлаар дүрслэх 9.1д. Детальд нүүрний, хажуугийн, хэвтээ байршилтай хавтгайгаар зүсэлт хийж ортогональ проекцод дүрслэх талс биет ба деталийг изометр проекцын тэнхлэг дээр 1/4 зүсэлтээр дүрслэх 9.1е. Өгсөн эдлэлд хэрэглэх холбоосын хэрэгцээг илрүүлж онцлогийг ялган таних	Дизайн, зураг зүй	ДТ9.1.ҮД1. Сурагч деталийг огтлол, зүсэлтийн аргаар зурж дүрсэлж чаддаг болно.
	9.1а. Өгсөн эд зүйлийн хэрэглээ, мөн чанар, онцлогийг тусган харуулах замаар барааны тэмдэгийн дизайн шийдэл хийх, өөрчлөх 9.1б. Эд зүйлсийн дизайн шийдлийг төлөвлөн зурах, дизайнд дүн шинжилгээ хийх, эдлэлийн загвар бүтээх 9.1в. Бүтээгдэхүүний загварын хэрэглээний шаардлагад дүн шинжилгээ хийх замаар шинэ загвар бүтээх		ДТ9.1.ҮД2. Сурагч бүтээгдэхүүний хэрэглээний шаардлагад нийцүүлэн загварт өөрчлөлт хийх, загварын онцлог мөн чанарыг харуулсан барааны тэмдэгт зохион бүтээж чаддаг болно.
2	9.2а. Цардах, хэлбэршүүлэх, наах аргуудаар байгалийн ба нийлмэл материалын шинж чанарыг өөрчлөх, зохион бүтээх ажилдаа хэрэглэх 9.2б. Оёдлын машины туслах төхөөрөмж ашиглан, төрөл бүрийн оёдлуудыг оёж гүйцэтгэх	Боловсруулах технологи /А групп/	ДТ9.2.ҮД3. Сурагч оёдлын машины туслах төхөөрөмж (оёдлын ул) ашиглан төрөл бүрийн оёдлуудыг оёх, чийг дулааны ажиллагааг гүйцэтгэж чаддаг болно.
	9.2г. Монгол үндэсний хувцасны эсгүүрийг уламжлалт аргачлалаар байгуулах 9.2д. Уламжлалт аргаар монгол үндэсний хувцас эсгэх, оёх, материал, багаж, технологи дарааллыг схем тэмдэглэгээ ашиглан төлөвлөж бичих 9.2е. Технологийн дараалал, зааврын дагуу монгол хувцас эсгэж, оёх, чимэглэх		ДТ9.2.ҮД4. Сурагч уламжлалт технологиор дээл (баривч) эсгэж, оёж чаддаг болно.
	9.2в. Уран зангилаа, зүймэл урлал, уран хатгамлын арга ашиглан эдлэл зохион бүтээх		ДТ9.2.ҮД5. Сурагч зүймэл урлал, уран хатгамлын технологиос сонгон жижиг эдлэл хийж чаддаг болно.
	9.2ж. Уламжлалт аргаар тараг, аарц, ааруул бэлтгэх 9.2з. Цагаан идээ боловсруулах уламжлалт ба орчин үеийн үйлдвэрлэлийн аргын ялгааг тодруулах		ДТ9.2.ҮД6. Сурагч уУламжлалт аргаар цагаан идээ (тараг, аарц, ааруул) бэлтгэж чаддаг болно.

3	<p>9.2и. Баруун гараар хутгыг барьж, зүүн гараар хамгаалж түлхэх аргаар цоолбор ба бүтэн сийлбэр хийх</p> <p>9.2к. Сийлбэрийн төрлөөс хамаарч, үндсэн ба туслах багажийг сонгох</p> <p>9.2л. Тусгай зориулалтын багаж, тоног төхөөрөмжийг ААД-ийг баримтлан зааврын дагуу ажиллах.</p> <p>9.2м. Гар уран хөрөө, цахилгаан уран хөрөөг зөв арга барилаар ашигласнаар муруй шугаман гадаргуутай модон эд ангийг бүтээх</p>	Боловсруулах технологи /Б групп	<p>ДТ9.2.ҮД7. Сурагч гар ба цахилгаан багаж (цахилгаан суурин өрөм, уран хөрөө, гар хөрөө, зүлгүүр), тусгай зориулалт (сийлбэр)-ын багажаар мод боловсруулах технологиор сийлбэртэй (хүрээлбэр, хагас товгор, цоолбор, бүтэн) жижиг эдлэл хийж чаддаг болно.</p>
	<p>9.2н. Хатаах, хат хариулах, уяраах аргуудаар байгалийн ба нийлмэл материалын шинж чанарыг өөрчлөх, зохион бүтээх ажилдаа хэрэглэх</p> <p>9.2о. Дархны урлалын арга, төрөл, зориулалтыг эдлэлийн жишээн дээр тайлбарлах</p> <p>9.2ө. Хөөмлийн багажийн ажлын хэсгийн хэлбэрийг хөөмлийн технологийн жишээгээр тайлбарлах, бүтээл хийхдээ сонгож хэрэглэх</p>		<p>ДТ9.2.ҮД8. Сурагч дархны урлалын төрөл, багаж хэрэгсэл, аргыг судалж хөөмлийн технологиор жижиг эдлэл хийж чаддаг болно.</p>
4	<p>9.3а. Техникийн хөгжил, зохион бүтээлтийн түүхээс (усан онгоцны хөгжлийн түүх гэх мэт) хөгжлийн гол хүчин зүйлийн гаргалгаа хийх</p> <p>9.3б. Машины төрлийг жишээгээр тайлбарлах</p>	Техник	<p>ДТ9.3.ҮД9. Сурагч техникийн (усан онгоц) хөгжлийн түүх, усан загварын төрөл ангилал болон хүний хөдөлмөр хөнгөвчлөх машины жишээгээр ангилал, зориулалтыг тайлбарлаж чаддаг болно.</p>
	<p>9.3в. Энгийн болон нийлмэл цахилгаан хэлхээ бүхий, хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх техникийн бүтээл зохион бүтээх</p> <p>9.3г. Эд ангийн таних тэмдэг ашиглан технологийн машины бүдүүвч унших</p>		<p>ДТ9.3.ҮД10. Сурагч энгийн болон нийлмэл цахилгаан хэлхээг ашиглан хүний хөдөлмөр хөнгөвчлөх техникийн бүтээл хийж чаддаг болно.</p>

#### 4.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

##### 4.2.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. ДИЗАЙН, ЗУРАГ ЗҮЙ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДТ9.1.ҮД1. Сурагч деталийг огтлол, зүсэлтийн аргаар зурж дүрсэлж чаддаг болно.	ДТ9.1.ҮД1.Ш1. Деталийг огтлогч хавтгайгаар огтлоход үүссэн дүрсийг шилжүүлсэн дүрслэлийн аргаар зурдаг.
		ДТ9.1.ҮД1.Ш2. Деталийг огтлогч хавтгайгаар огтлоход үүссэн дүрсийг давхцуулсан дүрслэлийн аргаар зурдаг.
		ДТ9.1.ҮД1.Ш3. Деталийг проекцлогч (нүүрний, хажуугийн, хэвтээ) хавтгайгаар зүсэлт хийж ортогональ проекцын аргаар зурдаг.
		ДТ9.1.ҮД1.Ш4. Деталийн 1/4 зүсэлтийг изометр проекцын тэнхлэг дээр зурдаг.
2	ДТ9.1.ҮД2. Сурагч бүтээгдэхүүний хэрэглээний шаардлагад нийцүүлэн загварт өөрчлөлт хийх, загварын онцлог мөн чанарыг харуулсан барааны тэмдэгт зохион бүтээж чаддаг болно.	ДТ9.1.ҮД2.Ш5. Эд зүйлсийн хэрэглээний шаардлагад дүн шинжилгээ хийх замаар өөрчлөлт хийн шинэ загвар бүтээдэг.
		ДТ9.1.ҮД2.Ш6. Бүтээгдэхүүний хэрэглээ, мөн чанар, онцлогийг тусгасан барааны тэмдэгт зохион бүтээдэг.



## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

### Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
ДТ9.1.ҮД1.Ш1. Деталийг огтлогч хавтгайгаар огтлоход үүссэн дүрсийг шилжүүлсэн дүрслэлийн аргаар зурдаг.	Деталийн бүтцийг тодорхойлж, проекц дүрслэлийг зурдаг.	Деталийн огтлогч хавтгайн байршлыг тодорхойлж тэмдэглэдэг.	Деталийн огтлогч хавтгай дээр үүссэн мөрийг (45° налуу зураас) зурдаг.	Деталийг огтлогч хавтгайгаар огтлоход үүссэн дүрсийг шилжүүлсэн дүрслэлийн аргаар зурдаг.
ДТ9.1.ҮД1.Ш2. Деталийг огтлогч хавтгайгаар огтлоход үүссэн дүрсийг давхцуулсан дүрслэлийн аргаар зурдаг.	Деталийн бүтцийг тодорхойлж, проекц дүрслэлийг зурдаг.	Деталийн огтлогч хавтгайн байршлыг тодорхойлж, тэгш хэмийн (X, Y) тэнхлэгийн дагуу дунд тасалж зурдаг.	Деталийн проекц дүрслэл дээр огтлогч хавтгайн үүссэн мөрийг (45° налуу зураас) зурдаг.	Деталийг огтлогч хавтгайгаар огтлоход үүссэн дүрсийг давхцуулсан дүрслэлийн аргаар зурдаг.
ДТ9.1.ҮД1.Ш3. Деталийг проекцлогч (нүүрний, хажуугийн, хэвтээ) хавтгайгаар зүсэлт хийж ортогональ проекцын аргаар зурдаг.	Деталийн нүүрний проекцод проекцлогч хавтгайгаар зүсэлт хийж ортогональ проекцын аргаар зурдаг.	Деталийн хэвтээ проекцод проекцлогч хавтгайгаар зүсэлт хийж ортогональ проекцын аргаар зурдаг.	Деталийн хажуугийн проекцод проекцлогч хавтгайгаар зүсэлт хийж ортогональ проекцын аргаар зурдаг.	Деталийг проекцлогч (нүүрний, хажуугийн, хэвтээ) хавтгайгаар зүсэлт хийж ортогональ проекцын аргаар зурдаг.
ДТ9.1.ҮД1.Ш4. Деталийн 1/4 зүсэлтийг изометр проекцын тэнхлэг дээр зурдаг.	Деталийн бүтцийг тодорхойлж, изометрийн тэнхлэг дээр зурдаг.	Деталийн изометр проекц дээр тэгш хэмийн тэнхлэгийн дагуу нүүрний ба хажуугийн проекцод проекцлогч хавтгайгаар зүсэлтийг тэмдэглэдэг.	Деталийн изометр проекцын тэгш хэмийн тэнхлэг дээр 1/4 зүсэлтийг байгуулж, ил харагдах ирмэг хөвөөг зурдаг.	Деталийн изометр проекцын тэгш хэмийн тэнхлэг дээр 1/4 зүсэлтийн хавтгай дээр материалыг зурааслан ялган зурдаг.
ДТ9.1.ҮД2.Ш5. Эд зүйлсийн хэрэглээний шаардлагад дүн шинжилгээ хийх замаар өөрчлөлт хийн шинэ загвар бүтээдэг.	Эд зүйлсийн хэрэглээний шаардлагыг тайлбарладаг.	Эд зүйлсийн хэрэглээний шаардлагад нийцүүлэн загварын санаагаа зургаар (ажлын) илэрхийлдэг.	Эд зүйлсийн туршилтын биет загварыг (макет) бүтээж туршдаг.	Эд зүйлсийн хэрэглээний шаардлагад нийцсэн шинэ загвар бүтээдэг.
ДТ9.1.ҮД2.Ш6. Бүтээгдэхүүний хэрэглээ, мөн чанар, онцлогийг тусгасан барааны тэмдэгт зохион бүтээдэг.	Бүтээгдэхүүний хэрэглээг судлан, түүний мөн чанар, онцлогийг жишээн дээр тайлбарладаг.	Бүтээгдэхүүний хэрэглээ, мөн чанар, онцлогийг тусгасан жагсаалт гаргаж барааны тэмдэгтийн загварын санаагаа зурдаг.	Бүтээгдэхүүний барааны тэмдэгтийн загварыг геометр байгуулалтын аргаар зурдаг.	Хэрэглээнд нийцсэн барааны тэмдэгт зохион бүтээдэг.

**4.2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ /А ГРУПП/**

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДТ9.2.ҮД3. Сурагч оёдлын машины туслах төхөөрөмж (оёдлын ул) ашиглан төрөл бүрийн оёдлуудыг оёх, чийг дулааны ажиллагааг гүйцэтгэж чаддаг болно.	ДТ9.2.ҮД3.Ш1. Оёдлын машины ул, тохиргоог өөрчлөх замаар олон оёдлоор оёдог.
		ДТ9.2.ҮД3.Ш2. Индүүдлэгийн тохиргоо хийх, аргаар чийг дулааны ажиллагааг гүйцэтгэдэг.
2	ДТ9.2.ҮД4. Сурагч уламжлалт технологиор дээл (баривч) эсгэж, оёж чаддаг болно.	ДТ9.2.ҮД4.Ш3. Дээл (баривч)-ийн эсгүүрийг дарааллын дагуу байгуулдаг.
		ДТ9.2.ҮД4.Ш4. Дээл (баривч)-ийг материалын өргөн, хээнд тохируулан уламжлалт аргаар эсгэдэг.
		ДТ9.2.ҮД4.Ш5. Уламжлалт арга, технологийн дагуу зах, ханцуй, энгэрийг эмжиж бэлтгэдэг.
		ДТ9.2.ҮД4.Ш6. Дээл (баривч)-ийн бүрдэл хэсгүүдийг технологи дарааллын дагуу нэгтгэж оёдог.
3	ДТ9.2.ҮД5. Сурагч зүймэл урлал, уран хатгамлын технологиос сонгон жижиг эдлэл хийж чаддаг болно.	ДТ9.2.ҮД5.Ш8. Зүймэл урлал эсвэл хатгамлын технологийг сонгон судлах замаар хийх эдлэлийн загварыг төлөвлөн зурдаг.
		ДТ9.2.ҮД5.Ш9. Зүймэл урлал эсвэл хатгамлын технологиор жижиг эдлэл оёдог.
4	ДТ9.2.ҮД6. Сурагч уламжлалт аргаар цагаан идээ (тараг, аарц, ааруул) бэлтгэж чаддаг болно.	ДТ9.2.ҮД6.Ш10. Цагаан идээ боловсруулах уламжлалт ба орчин үеийн үйлдвэрлэлийн аргын ялгааг харьцуулан тайлбарладаг.
		ДТ9.2.ҮД6.Ш11. Уламжлалт аргаар цагаан идээ (тараг, аарц, ааруул) боловсруулдаг.

**Гүйцэтгэлийн түвшин**

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
ДТ9.2.ҮД3.Ш1. Оёдлын машины ул, тохиргоог өөрчлөх замаар олон оёдлоор оёдог.	Товчны нүх хэрэх болон зиг заг оёдлоор оёх ул (үндсэн) болон оёдлын тохиргоог тохируулж оёдог.	Цахилгаан товч оёх ул болон оёдлын тохиргоог тохируулж оёдог.	Эмхэрдэж оёх ул болон оёдлын тохиргоог тохируулж оёдог.	Оёдлын машины ул, тохиргоог өөрчлөх замаар эдлэлийг оёх технологид тохируулан сонгож оёдог.
ДТ9.2.ҮД3.Ш2. Индүүдлэгийн тохиргоо хийх, аргаар чийг дулааны ажиллагааг гүйцэтгэдэг.	Материалын шинж чанар, индүүдлэгийн чийг дулааны ажиллагааны хамаарлыг тайлбарладаг.	Индүүдлэгийн (даавууг оёхоос өмнө ууршиж индүүдэх, оёог хагалж индүүдэх, хэлбэржүүлэн индүүдэх) аргуудаар индүүддэг.	Материалын шинж чанарт тохируулан индүүдлэгийн тохиргоо хийж чийг дулааны ажиллагааг гүйцэтгэдэг.	Зохион бүтээх ажилдаа тохируулан чийг дулааны ажиллагааг ААД баримтлан гүйцэтгэдэг.

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

ДТ9.2.ҮД4.Ш3. Дээл (баривч)-ийн эсгүүрийг дарааллын дагуу байгуулдаг.	Дээл (баривч)-ны эсгүүрт ашиглах биеийн хэмжээг (Тх, Тц,Тбуг, Уд, Ух) аргачлалын дагуу зөв хэмждэг.	Тооцоолох арга ашиглан дээл (баривч)-ны эсгүүрийн торыг масштаб шугам (М1:4) ашиглан байгуулдаг.	Тооцоолох арга ашиглан дээл (баривч)-ийн бүрдэл хэсгүүдийн (их бие, энгэр, зах, захын ухлаадасны хэв) эсгүүрийг масштаб шугам (М1:4) ашиглан байгуулдаг.	Сонгосон биеийн хэмжээгээр дээл (баривч)-ийн эсгүүрийг М1:1 хэмжээгээр байгуулж эсгүүрийн үлгэр бэлтгэдэг.
ДТ9.2.ҮД4.Ш4. Дээл (баривч)-ийг материалын өргөн, хээнд тохируулан уламжлалт аргаар эсгэдэг.	Дээл эсгэх уламжлалт аргуудыг туршиж үр дүнг харьцуулан тайлбарладаг.	Дээл (баривч)-ийн зориулалт, хэрэглээнд нийцүүлэн материалыг сонгодог.	Материалын өргөн, хээнд тохируулан эсгэх уламжлалт аргуудаас сонгодог.	Дээл (баривч)-ийг материалын өргөн, хээнд тохируулан уламжлалт аргаар эсгэдэг.
ДТ9.2.ҮД4.Ш5. Уламжлалт арга, технологийн дагуу зах, ханцуй, энгэрийг эмжиж бэлтгэдэг.	Уламжлалт болон зориулалтын наалтын материал хэрэглэх аргуудаар эмжих хэсэгт (энгэр, ханцуй, зах) цаваг (хатуулга) бэлтгэж наадаг.	Уламжлалт аргаар эмжээрийг бэлтгэж эмждэг.	Уламжлалт аргаар хажлага бэлтгэж оёдог.	Уламжлалт арга, технологийн дагуу зах, ханцуй, энгэрийг эмжиж хажлага бэлтгэж оёдог.
ДТ9.2.ҮД4.Ш6. Дээл (баривч)-ийн бүрдэл хэсгүүдийг технологи дарааллын дагуу нэгтгэж оёдог.	Дээл (баривч)-ийн бүрдэл хэсгүүдийг нэгтгэх технологи ажилбарын схем тэмдэглэгээ болон дарааллыг төлөвлөдөг.	Дээл (баривч)-ны бүрдэл хэсгүүдийг (ар, энгэрийн гол, хормой, хажуу гэх мэт) дарааллын дагуу схем тэмдэглэгээг ашиглан нэгтгэж оёдог.	Дээл (баривч)-ийг сугалах аргаар нэгтгэж, хавж оёдог.	Дээл (баривч)-ийн бүрдэл хэсгүүдийг технологи дарааллын дагуу нэгтгэж оёдог.
ДТ9.2.ҮД4.Ш7. Уламжлалт аргаар товч, шилбийг бэлтгэж оёдог.	Уламжлалт аргаар шилбэ бэлтгэдэг.	Уламжлалт аргаар товч бэлтгэдэг. (сампин зангидах)	Товч, шилбийг технологийн (тэмдэглэх, оёх) дагуу хаддаг.	Товч, шилбийг хэлбэрт оруулан чимэглэж хаддаг.
ДТ9.2.ҮД5.Ш8. Зүймэл урлал эсвэл хатгамлын технологийг сонгон судлах замаар хийх эдлэлийн загварыг төлөвлөн зурдаг.	Зүймэл урлал эсвэл хатгамлын технологийн онцлогийг тайлбарладаг.	Эдлэлийг хийсэн зүймэл урлал болон хатгамлын арга, технологи дарааллыг бүтээлийн жишээгээр тайлбарладаг.	Зүймэл урлал болон хатгамлын технологи ашиглан хийх эдлэлийн загварыг хувилбартайгаар зурдаг.	Зүймэл урлал эсвэл хатгамлын технологи ашиглан хийх эдлэлийн сонгосон загварыг сайжруулан төлөвлөн зурдаг.
ДТ9.2.ҮД5.Ш9. Зүймэл урлал эсвэл хатгамлын технологиор жижиг эдлэл оёдог.	Жижиг эдлэлийн загвар, хэрэглээнд нийцүүлэн багаж хэрэгсэл, материалыг сонгодог.	Сонгосон технологиор жижиг эдлэл оёх технологи дарааллыг төлөвлөдөг.	Зүймэл урлал эсвэл хатгамлын технологиор оёх эдлэлийн бүрдэл хэсгүүдийг тооцоолж бэлтгэдэг.	Төлөвлөлтийн дагуу зүймэл урлал эсвэл хатгамлын технологиор жижиг эдлэл оёдог.

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

ДТ9.2.ҮД6.Ш10. Цагаан идээ боловсруулах уламжлалт ба орчин үеийн үйлдвэрлэлийн аргын ялгааг харьцуулан тайлбарладаг.	Цагаан идээний төрөл ангиллыг нэрлэдэг.	Цагаан идээ боловсруулах уламжлалт аргуудыг тайлбарладаг.	Цагаан идээ боловсруулах орчин үеийн үйлдвэрлэлийн аргууд, багаж хэрэгслийг тайлбарладаг.	Цагаан идээ боловсруулах уламжлалт ба орчин үеийн үйлдвэрлэлийн аргын ялгааг харьцуулан тайлбарладаг.
ДТ9.ҮД6.Ш11. Уламжлалт аргаар цагаан идээ (тараг, аарц, ааруул) боловсруулдаг.	Бүтээгдэхүүнийг боловсруулах арга, технологи нийцүүлэн орцыг сонгож тооцоолдог.	Цагаан идээ боловсруулах технологи ажиллагаа болон хугацааг тооцож төлөвлөдөг.	Технологи ажиллагаа, дарааллын дагуу цагаан идээ (тараг, аарц, ааруул) боловсруулдаг.	Цагаан идээг жорын хувьд баяжуулан боловсруулдаг.

### 4.2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ /Б ГРУПП/

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДТ9.2.ҮД7. Сурагч гар ба цахилгаан багаж (цахилгаан суурин өрөм, уран хөрөө, гар хөрөө, зүлгүүр), тусгай зориулалт (сийлбэр)-ын багажаар мод боловсруулах технологиор сийлбэртэй (хүрээлбэр, хагас товгор, цоолбор, бүтэн) жижиг эдлэл хийж чаддаг болно.	ДТ9.2.ҮД7.Ш1. Модон материалын физик шинж чанар(хатуу, зөөлөн, нягт, сийрэг)-ыг тодорхойлж (сийлбэртэй) эдлэлийн онцлогт нийцүүлэн сонгодог.
		ДТ9.2.ҮД7.Ш2. Сийлбэрийн үндсэн болон туслах багажаар уран хөрөөгөөр хөрөөдөх, ухах, зорох, засах технологийг гүйцэтгэж чаддаг.
		ДТ9.2.ҮД7.Ш3. Сийлбэр хийх арга технологиор ААД баримтлан сийлбэртэй (хүрээлбэр, хагас товгор, цоолбор, бүтэн) жижиг эдлэл хийдэг.
2	ДТ9.2.ҮД8. Сурагч дархны урлалын төрөл, багаж хэрэгсэл, аргыг судалж хөөмлийн технологиор жижиг эдлэл хийж чаддаг болно.	ДТ9.2.ҮД8.Ш4. Дархны урлалын арга (хатаах, хат хариулах, уяраах), төрөл зориулалтыг эдлэлийн жишээгээр тайлбарладаг.
		ДТ9.2.ҮД8.Ш5. Хөөмлийн технологиор жижиг эдлэл хийдэг.

### Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
ДТ9.2.ҮД7.Ш1. Модон материалын физик шинж чанарыг (хатуу, зөөлөн, нягт, сийрэг) тодорхойлж (сийлбэртэй) эдлэлийн онцлогт нийцүүлэн сонгодог.	Модон материалын физик шинж чанар (хатуу, зөөлөн, нягт, сийрэг)-ыг эдлэлийн жишээн дээр тодорхойлдог.	Модон материалын физик (хатуу, зөөлөн, нягт, сийрэг) шинж чанарыг зорох, ухах технологиор тодорхойлдог	Модон материалуудын физик (хатуу, зөөлөн, нягт, сийрэг) шинж чанарыг харьцуулж тодорхойлдог.	Модон материалын шинж чанараар нь эдлэлийн онцлогт нийцүүлэн сонгодог.
ДТ9.2.ҮД7.Ш2. Сийлбэрийн үндсэн болон туслах багажаар уран хөрөөгөөр хөрөөдөх, ухах, зорох, засах технологийг гүйцэтгэж чаддаг.	Сийлбэрийн төрлийн багаж хэрэгслийг (үндсэн ба туслах) ангилж тодорхойлдог.	Уран хөрөөгөөр муруй шугаман гадаргууг ААД баримтлан хөрөөдөж чаддаг.	Баруун гараар хутгыг барьж, зүүн гараар хамгаалж түлхэх арга ухах, зорох технологийг ААД баримтлан хийж чаддаг.	Ухам хутга, сам ашиглан ухах, зорох, засах технологийг ААД баримтлан хийдэг.



## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

ДТ9.2.ҮД7.Ш3. Сийлбэр хийх арга технологиор ААД баримтлан сийлбэртэй (хүрээлбэр, хагас товгор, цоолбор, бүтэн) жижиг эдлэл хийдэг.	Сийлбэрийн эх загварыг гадаргуугийн хэмжээгээр байгуулан гадаргуу дээр дүрсэлдэг.	Сийлбэрийн туслах багаж ашиглан сийлэх технологийн огтлох, зүсэх, тайрах, технологийг ААД баримтлан гүйцэтгэдэг.	Сийлбэрийн үндсэн багаж ашиглан дан буюу давхар ухах, сийлэх технологийг ААД баримтлан гүйцэтгэдэг.	Сийлбэрийг засварлах, өнгөлөх, чимэглэх, лакдак технологийг ААД баримтлан гүйцэтгэж жижиг эдлэл хийдэг.
ДТ9.2.ҮД8.Ш4. Дархны урлалын арга (хатаах, хат хариулах, уяраах), төрөл зориулалтыг эдлэлийн жишээгээр тайлбарладаг.	Монгол дархны урлалд хэрэглэгддэг металлуудыг эдлэлийн жишээгээр нэрлэдэг.	Монгол дархны урлалын төрлүүдийг эдлэлийн жишээгээр тайлбарладаг.	Монгол дархны (хатаах, хат хариулах, уяраах) технологийг тайлбарладаг.	Монгол дархны урлалын зориулалтыг эдлэлийн жишээн дээр тайлбарладаг.
ДТ9.2.ҮД8.Ш5. Хөөмлийн технологиор жижиг эдлэл хийдэг.	Хөөмөлд хэрэглэх багаж хэрэгслийг сонгож чаддаг.	Хөөмөлд хэрэглэх багаж хэрэгслийн ажиллах арга барилыг тодорхойлдог.	Хөөмөл хийх ажлын дарааллыг тодорхойлдог.	Ундааны сав ашиглан энгийн ингэмэл хөөмлийн технологиор жижиг бүтээл хийдэг.

### 4.2.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. ТЕХНИК

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДТ9.3.ҮД9. Сурагч техникийн (усан онгоц) хөгжлийн түүх, усан загварын төрөл ангилал болон хүний хөдөлмөр хөнгөвчлөх машины жишээгээр ангилал, зориулалтыг тайлбарлаж чаддаг болно.	ДТ9.3.ҮД9.Ш1. Техникийн (усан онгоц) түүхэн хөгжил, усан загварын төрөл ангиллыг тодорхойлж тайлбарладаг.
		ДТ9.3.ҮД9.Ш2. Хүний хөдөлмөр хөнгөвчлөх машины (мэдээллийн, ажлын, энергийн, кибернетик машин) жишээгээр ангилал, зориулалтыг тайлбарладаг.
2	ДТ9.3.ҮД10. Сурагч энгийн болон нийлмэл цахилгаан хэлхээг ашиглан хүний хөдөлмөр хөнгөвчлөх техникийн бүтээл хийж чаддаг болно.	ДТ9.3.ҮД10.Ш3. Цахилгаан хэлхээний бүдүүвч, кинематик зураг зурдаг.
		ДТ9.3.ҮД10.Ш4. Энгийн болон нийлмэл цахилгаан хэлхээг ашиглан хүний хөдөлмөр хөнгөвчлөх техникийн бүтээл хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
ДТ9.3.ҮД9.Ш1. Техникийн (усан онгоц) түүхэн хөгжил, усан загварын төрөл ангиллыг тодорхойлж тайлбарладаг.	Техникийн хөгжлийн үе шатыг усан онгоцны жишээгээр тайлбарладаг.	Техникийн хөгжил (загварын болон технологийн)-ийн өөрчлөлтийг усан онгоцны жишээгээр харьцуулж тайлбарладаг.	Техникийн (усан онгоц) хөгжлийг усан загварын спортын төрлүүдтэй холбож тайлбарладаг.	Техникийн (усан онгоц) хөгжил болон усан загварын төрөл, ангилал, тэмцээний үнэлгээний зарчмыг тайлбарладаг.
ДТ9.3.ҮД9.Ш2. Хүний хөдөлмөр хөнгөвчлөх машины (мэдээллийн, ажлын, энергийн, кибернетик машин) жишээгээр ангилал, зориулалтыг тайлбарладаг.	Машины тухай ерөнхий ойлголтоо тодорхойлдог.	Хүний хөдөлмөр хөнгөвчлөх машины төрөл ангиллыг нэрлэдэг.	Хүний хөдөлмөр хөнгөвчлөх машины төрөл ангиллыг жишээгээр тайлбарладаг.	Машины төрөл ангилал, зориулалтыг хүний хөдөлмөр хөнгөвчлөх машины жишээгээр тайлбарладаг
ДТ9.3.ҮД10.Ш3. Цахилгаан хэлхээний бүдүүвч, кинематик зураг зурдаг.	Цахилгаан хэлхээний бүдүүвч, кинематик тэмдэглэгээг таньж нэрлэдэг.	Цахилгаан хэлхээний бүдүүвч, кинематик схемийг уншиж тайлбарладаг.	Техникийн бүтээлийн цахилгаан хэлхээ (энгийн болон нийлмэл)-ний бүдүүвч зурдаг.	Техникийн бүтээлийн цахилгаан хэлхээний бүдүүвч, кинематик схемийг зурдаг.
ДТ9.3.ҮД10.Ш4. Энгийн болон нийлмэл цахилгаан хэлхээг ашиглан хүний хөдөлмөр хөнгөвчлөх техникийн бүтээл хийдэг.	Хүний хөдөлмөр хөнгөвчлөх техникийн бүтээлийн загварын санаа, ажиллах зарчмыг зурж тайлбарладаг.	Хүний хөдөлмөр хөнгөвчлөх техникийн бүтээлийн ажлын зургийг зурдаг.	Ажлын зургийн дагуу эд ангиудыг бэлтгэх, холбож, угсрах аргаар хүний хөдөлмөр хөнгөвчлөх техникийн бүтээлийг хийдэг.	Хүний хөдөлмөр хөнгөвчлөх техникийн бүтээлийн хөдөлгөөн дамжуулах механизм, электроникийн бүрдэл хэсгийн ажиллагааг туршиж сайжруулдаг.

**“ЕБС-ийн Дүрслэх урлаг, технологи, Дизайн зураг зүй хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-ыг боловсруулсан ажлын хэсэг:**

С.Отгонтуяа	Боловсролын хүрээлэн, ЭША, магистр
Ч.Алтанчимэг	20 дугаар сургуулийн багш, зөвлөх
Б.Мөнхтуяа	“Амгалан” цогцолбор сургуулийн багш, магистр
С.Цолмон	“Шинэ эхлэл” сургуулийн багш, зөвлөх
Ж.Энхбаатар	“Шинэ зуун билэг” сургуулийн багш, зөвлөх

**Хөндлөнгийн шинжээч:**

Д.Хөхөө	МУБИС-ийн ДУТС-ийн зөвлөх багш, доктор (Ph.D), дэд профессор
---------	--

**Техникийн редактор:**

Г.Дэлгэрмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, доктор (Ph.D)
-------------	--

**Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:**

Э.Сансартуяа	“Хас дизайн пресс” ХХК-ийн дизайнер
Л.Алтансүх	Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн





БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
**БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ**

## **БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо  
Энхтайваны өргөн чөлөө, Арслантай гүүр  
“ОЮУНЫ УНДРАА” группийн байр

---

Утас: 70119498, 70118485  
И-мэйл: [info@ees.mn](mailto:info@ees.mn)